



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 29 өдөр

Дугаар A/244

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэлж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.14 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны A/52 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны A/03 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зудын улмаас үхэж хорогдсон малын сэг зэмийг устгах, халдвартгүйтгэлийн арга хэмжээнд орон нутгийн тэр, захиргааны байгууллага, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүн хүч, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавих бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Малын сэг, зэмийн устгалын арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Улаан загалмайн хороо (З.Батзориг) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат) –д даалгасугай.






تذكرة ملوك

۱۰

$$\frac{2}{\sqrt{3}} \quad \frac{1}{\sqrt{3}} \quad \frac{1}{\sqrt{3}}$$

بَعْدَهُمْ وَلِنَفْسِهِ مَحْسُورٌ



Аймгийн Засаг даргын
03 дугаар сарын 09-ны өдрийн
захирамжийн хавсралт

**МАЛЫН СЭГ, ЗЭМ УСТГАХ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН УЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ ХУВААРЬ**

Д/Д	Сумын нэр	Нэр	Албан тушаал
1	Дэлгэр, Чандмана	З.Батзориг	Улаан загалмайн хорооны дарга
2		Ц.Амарсанаа	Онцгой байдлын газрын эрэн хайх, аврах салбарын захирагч, хошууч
3		Ү.Сосорбурам	Аврагч-жолооч, холбоочин, дэд ахлагч
4		Д.Наянбуу	Мал, эмнэлгийн газрын мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга
5		Э.Пүрэвдорж	Хүнс, хөдөө, аж ахуйн газрын малын тэжээл, бэлчээр, усан хангамж хариуцсан мэргэжилтэн
6	Бигэр, Халиун	Х.Баатарзориг	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
7		М.Алтансүх	Онцгой байдлын газрын эрэн хайх, аврах салбарын бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, ахлах дэслэгч
8		Ч.Эрхэмбаяр	Мал, эмнэлгийн газрын лабораторийн эрхлэгч
9		Н.Санждамба	Хүнс, хөдөө, аж ахуйн газрын малын генетик, неец ашиглалт, эрчимжсэн мал аж ахуй, мэдээ, тайлан хариуцсан мэргэжилтэн
10		Ш.Энх-Амгалан	Мал, эмнэлгийн газрын жолооч

ооо